МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 22 өдөр Дугаар А/359 Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1, 2.1.4, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Онцгой байдлын ерөнхий газар хамтран 2023 оны 06 дугаар сарын 07-09-ний өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулагдсан газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх "Стратегийн команд штаб"-ын сургуулийн үйл ажиллагаанд 4,387,000 (Дөрвөн сая гурван зуун наян долоо мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 4,387,000 (Дөрвөн сая гурван зуун наян долоо мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3. Зардалтай холбоотой шаардлагатай баримт бичгийг бүрдүүлж, тайлагнаж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа (Ё.Пүрэвсүрэн)- д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (М.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж-2023

6713010737